Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 393,954.0 мянган төгрөгөөр буюу 11 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт           |
|--|--------------------|--------------------|--------------------|
| Б  | 1                  | 2                  | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                               | 0                  | 0                  | 0                  |
| Авлага                                       | 10,849.5           | 20,292.7           | 9,443.2            |
| Бараа материал                               | 176,034.9          | 192,711.2          | 16,676.3           |
| Нөөцийн бараа                                | 46,500.0           | 46,500.0           | -                  |
| Үндсэн хөрөнгө                               | 5,036,073.6        | 4,311,640.1        | (724,433.6)        |
| Хуримтлагдсан элэгдэл                        | (1,822,450.9)      | (1,518,090.8)      | 304,360.1          |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>3,447,007.2</b> | <b>3,053,053.2</b> | <b>(393,954.0)</b> |
| Өр төлбөр                                    | -                  | 251.3              | 251.3              |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 3,447,007.2        | 3,052,801.9        | (394,205.3)        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>3,447,007.2</b> | <b>3,053,053.2</b> | <b>(393,954.0)</b> |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2022 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Оны эхэнд авлагын дансны үлдэгдэл 10,849.5 мянган төгрөг байснаас нэмэлт санхүүжилтийн авлагын 6,500.0 мянган төгрөгийг барагдуулсан, байгууллагын нярваар ажиллаж байсан А.Мөнхтогтохтой холбоотой 4,349.5 мянган төгрөгийн авлага барагдаагүй, 2023 оны 06 дугаар сард аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаас хийсэн хяналт шалгалтаар тус албан хаагчтай өвс тэжээлийн үнийн дутагдалд нэмж 6,043.2 мянган төгрөгийг тогтоож, нийт 10,392.7 мянган төгрөгийн авлагатай болсон байна. Тус авлагыг барагдуулах албан шаардлагыг төсвийн захирагчид хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Шинэжинст сумын Засаг дарга Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгавар"-ыг баталж, 20,000.0 мянган төгрөгийг Шинэжинст сумын ЗДТГ-аас шилжүүлэхээр заасан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 9,900.0 мянган төгрөг шилжүүлэн ажлыг бүрэн хийж дуусаагүй байхад тайлант жилийн зардлаар тайлагнасан зөрчил аудитаар илэрч, санхүүгийн тайланд авлагаар залруулав.

Бараа материалын эхний үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 16,676.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 192,711.2 мянган төгрөг болсон нь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас 3 албан хаагчдад олгосон 8,898.6 мянган төгрөгийн хувцас, "Номгоны андууд" ХХК-аас үнэ төлбөргүй олгосон 9,739.9 мянган төгрөгийн өвс тэжээл, аж ахуйн материал 2,349.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө өмнөх оноос 724,433.6 мянган төгрөгөөр буурч 4,311,640.1 мянган төгрөг болсон нь төсвийн хөрөнгөөр 82,359.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 32,346.6 мянган төгрөгийн 2 мал угаалгын ванн, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/66 дугаар албан бичгээр 12,519.2 мянган төгрөгийн 2 сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжүүдийг орлогод авсан байна. Мөн аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 108 дугаар захирамжаар сумын хуучин Соёлын төвийн барилгыг 105,699.2 мянган төгрөгөөр орлогод авсан зэрэгтэй холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/08 дугаар тогтоолоор 947,629.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан ба үүнээс 920,000.0 мянган төгрөг нь сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж байжээ.

Оны эхэнд өглөггүй байсан ба тайлант хугацаанд 2 албан хаагчдад 251.3 мянган төгрөгийн өглөгтэй гарсныг санхүүгийн тайланд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 394,205.3 мянган төгрөгөөр буурч, 3,052,801.9 мянган төгрөг болсон байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 642,292.0 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 53,200.2 мянган төгрөгөөр хасаж, төсвийг 589,091.8 мянган төгрөгөөр баталсан нь тавилга эд хогшил, урсгал засварын зардлыг бууруулан баталсантай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Оны эхэнд баталсан анхны төсвийг сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 88 дугаар тогтоолоор 190,720.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 779,812.2 мянган төгрөгөөр баталж, 777,812.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгож, 2,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоор оруулахаар төлөвлөжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 (Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдах) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс баталсан 777,812.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, өөрийн орлогоор 792,4 мянган төгрөгийг оруулан, гүйцэтгэлээр 736,088.6 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 42,515.9 мянган төгрөгийг оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

| Код  | Үзүүлэлт   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү    | Биелэлт |
|------|--|------------|-----------|----------|---------|
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | 779,812.2  | 736,088.6 | 43,723.6 | 94.4    |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 743,645.1  | 700,630.5 | 43,014.6 | 94.2    |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 399,461.0  | 398,235.2 | 1,225.8  | 99.7    |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 49,932.6   | 49,932.1  | 0.5      | 100.0   |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 55,000.0   | 54,556.3  | 443.7    | 99.2    |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 67,257.7   | 63,633.1  | 3,624.6  | 94.6    |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 61,536.8   | 61,496.7  | 40.1     | 99.9    |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 6,110.0    | 5,352.4   | 757.6    | 87.6    |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 69,096.0   | 46,525.5  | 22,570.5 | 67.3    |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 35,251.0   | 20,899.1  | 14,351.9 | 59.3    |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын төсвийн хэлбэлзэл*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Өмнөговь аймгийн Засаг даргын А/264 дүгээр захирамжаар Шинэжинст сумын нутагт отроор явж байгаа малчдыг эргэх зардалд 5,000.0 мянга, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 942.3 мянга, “Хамтдаа шийдье аян” зохион байгуулах зардалд 740.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, өмнөх оны авлагын 6,500.0 мянган төгрөгийг барагдуулж орлогоор орж, түрээсийн төлбөрт 450.0 мянга, уул уурхайн барьцаа хөрөнгөд 3,375.0 мянга төгрөг орсон ба гүйцэтгэлээр 7,718.3 мянган

төгрөгийг зарцуулан, оны эцэст орон нутгийн орлогод 10,477.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах, менежментийг сайжруулж, төсвөөс зарцуулж буй хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.12.15-ны өдрийн 181 дүгээр албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2024.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 779,812.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,798.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,468.7 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг 2023.12.16-2023.12.17-ны өдрүүдэд гүйцэтгэж, аудитаар нийт 655,558.7 мянган төгрөгийн 12 зөрчил илэрч, зөвлөмж өгсөн бөгөөд оны эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд завсрын аудитаар өгсөн зарим зөвлөмжийг бүрэн биелүүлсэн, холбогдох арга хэмжээг авсан байгаа тул хэрэгжилтийг тооцож, асуудлын бүртгэлээс хассан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, 2,578.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 9,572.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт  |                 |      |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо      | Дүн             | Хувь |
| Акт             | 3                      | 2,578.0         | 3        | 2,578.0         | 100  |
| Албан шаардлага | 5                      | 9,572.1         | 5        | 9,572.1         | 100  |
| <b>Нийт дүн</b> | <b>8</b>               | <b>12,150.1</b> | <b>8</b> | <b>12,150.1</b> |      |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2022.04.13-ны өдрийн А/94 дүгээр албан бичиг

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын нярваар ажиллаж байсан А.Мөнхтогтохтой холбоотой өмнөх оны 4,349.5 мянга, 2023 оны 06 дугаар сард аймгийн ЗДТГ-ын дэргэдэх СХАА-аас хийсэн хяналт шалгалтаар тус албан хаагчтай өвс тэжээлийн үнийн дутагдалд нэмж 6,043.2 мянган төгрөгийг тогтоосон байхад 10,392.7 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлагыг барагдуулаагүй байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,127.9 мянган төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг залруулсан байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлд 2021 онд бүртгэсэн 53,900.0 мянган төгрөгийн 2 худаг, 2023 онд бүртгэсэн 12,519.0 мянган төгрөгийн Кантинар сэргээгдэх эрчим хүчийн ашиглах жилийг хасах 1 жилээр бүртгэснээс тухайн хөрөнгүүдэд элэгдэл тооцоогүй байгаа нь Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй тул санхүүгийн тайланд ашиглах жилийг оруулж залруулсан.
2. Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс байршуулсан 1,445.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байгаа нь Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй тул санхүүгийн тайланд залруулсан.
3. Шинэжинст сумын Засаг дарга Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгавар"-ыг баталж, 20,000.0 мянган төгрөгийг Шинэжинст сумын ЗДТГ-аас шилжүүлэхээр зааж, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 9,900.0 мянган төгрөг шилжүүлэн, ажлыг бүрэн хийж дуусаагүй байхад тайлант жилийн зардлаар тайлагнасан байгаа нь Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланд авлагаар залруулсан.
4. Шинэжинст сумын Орон нутгийн хөгжлийн сангаас тендерийн үнэлгээний хорооны гишүүдэд олгосон урамшууллыг сумын ЗДТГ-аар дамжуулан олгохдоо нэг гишүүний урамшууллыг олгоогүй атлаа тайлант жилийн орлогоор бүртгэсэн байгаа нь Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй тул санхүүгийн тайланд өглөгөөр залруулсан.

Аудитаар нийт 105,416.0 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс 96,116.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 9,300.0 мянган төгрөгийн дүн бүхий 1 зөвлөмжийг менежментийн захидлаар өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Байгууллагын санхүүгийн тайланд 2019 онд бүртгэсэн 12,360.0 мянган төгрөгийн 206 тоо толгой ухна ишиг, 37,256.0 мянган төгрөгийн 519 тоо толгой мал амьтан бүртгэлтэй байгаа нь малын А дансаар баталгаажаагүй, завсрын аудитаар мал амьтан байхгүй гэсэн тайлбарыг албан бичгээр ирүүлсэн, 11 дүгээр сард мал амьтныг санхүүгийн тайлангаас хассан байсан байхад 12 дугаар сард хийсэн жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлээр байгаагаар тоолж, тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.5 дахь “ Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх “Тооллогын комисс дараахь үүрэгтэй: эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэснийг зөрчсөн, Оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланд бүртгэлтэй мал амьтдын асуудлыг тодруулж, арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Санхүүгийн тайлангийн бусад нөөц дансанд 2018-2022 онуудад 5 төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийн 46,500.0 мянган төгрөгийг бүртгэж, үүнээс 3 төсөл арга хэмжээний тендер зарлаж, хэрэгжсэн байхад зураг төсвийн үнийг суутган тооцож аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.5 дахь “ Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг хэрэгжүүлээгүй тул зураг төсвийн үнийг холбогдох гүйцэтгэгч байгууллагуудаас суутган тооцож авлагыг барагдуулах албан шаардлагыг хүргүүлэв.

3. Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгааг тус байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан газартай тулган шалгахад Шинэжинст сумын ЗДТГ-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон 8 нэр бүхий газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайланд 636 м2, 1504 м2 талбай бүхий газрыг илүү бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх “ Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

4. Тусгай зориулалтын материал, бусад материалын тайланг гаргаж ирүүлээгүй, нярвын бэлтгэсэн бараа материалын тайлангийн сарын орлого, зарлагын дүн ерөнхий дэвтэр дэх дүнгээс зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалт болон УСНББОУС-16, УСНББОУС-18 стандартыг зөрчсөн тул бараа материалын тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв гаргах албан шаардлагыг хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын жилийн төсөвт хог хаягдлын хураамжийн зардалд тухайн жилд 25,137.6 мянган төгрөг баталж, хог хаягдлын гэрээг иргэнтэй байгуулж ажиллан, эхний 10 сарын байдлаар төсвөөс 12,800.0 мянган төгрөгийг олгосон байхад хог хаягдлын хураамжийн орлогоор 3,500.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаар санаачилгатай ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хог хаягдлын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох албан хаагчдад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

|  | Нийт алдаа |         | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |         | Буруу тусган илэрхийлсэн |         | Үүнээс     |         |              |     | Зөвлөмж |     |
|--|------------|---------|-----------------------------------|---------|--------------------------|---------|------------|---------|--------------|-----|---------|-----|
|  |            |         |                                   |         |                          |         | Залруулсан |         | Залруулаагүй |     |         |     |
|  | Тоо        | Дүн     | Тоо                               | Дүн     | Тоо                      | Дүн     | Тоо        | Дүн     | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Үндсэн хөрөнгөд 2021 онд бүртгэсэн 53,900,000 төгрөгийн 2 худаг, 2023.10.04-ний өдөр бүртгэсэн 12,519,000 төгрөгийн Кантинар сэргээгдэх эрчим хүчийг - 1 жилээр бүртгэсэн байна.   | 1          | 5,702.9 | 1                                 | 5,702.9 |                          |         | 1          | 5,702.9 |              |     |         |     |
| Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс байршуулсан 1,445.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.  | 1          | 1,445.0 |                                   |         | 1                        | 1,445.0 | 1          | 1,445.0 |              |     |         |     |
| Шинэжинст сумын Засаг дарга Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгавар"-ыг баталж, 20,000.0 мянган төгрөгийг Шинэжинст сумын ЗДТГ-аас шилжүүлэхээр заасан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 9,900.0 мянган төгрөг шилжүүлэн ажлыг бүрэн хийж дуусаагүй байхад тайлант жилийн зардлаар тайлагнасан байна. | 1          | 9,900.0 |                                   |         | 1                        | 9,900.0 | 1          | 9,900.0 |              |     |         |     |

|  |   |          |   |         |   |          |   |          |   |   |   |   |
|--|---|----------|---|---------|---|----------|---|----------|---|---|---|---|
| Сумын ОНХС-аас тендерийн үнэлгээний хорооны гишүүдэд олгосон урамшууллыг сумын ЗДТГ-аар дамжуулан олгосон бөгөөд нэг гишүүний урамшууллыг тайлант жилийн орлогоор бүртгэсэн байна. | 1 | 80.0     |   |         | 1 | 80.0     | 1 | 80.0     |   |   |   |   |
| Дүн  | 4 | 17,127.9 | 1 | 5,702.9 | 3 | 11,425.0 | 4 | 17,127.9 | 0 | 0 | 0 | 0 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |          | Үүнээс        |     |                 |          |         |     |                                      |                     |   |     |
|---|-------------|----------|---------------|-----|-----------------|----------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|   |             |          | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |          | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|   | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн | Тоо             | Дүн      | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Байгууллагын санхүүгийн тайланд 2019 онд бүртгэсэн 12,360.0 мянган төгрөгийн 206 тоо толгой ухна ишиг, 37,256.0 мянган төгрөгийн 519 тоо толгой мал амьтан бүртгэлтэй байгаа нь малын А дансаар баталгаажуулсангүй, завсрын аудитаар мал амьтан байхгүй гэсэн тайлбарыг албан бичгээр ирүүлсэн атлаа оны эцэст хийсэн тооллогоор байгаагаар тоолж, тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна. | 1           | 49,616.0 |               |     | 1               | 49,616.0 |         |     |                                      |                     |   |     |
| Бусад нөөц дансанд 2018-2022 онд бүртгэсэн 5 төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийн 46,500,000 төгрөгийг бүртгэж, үүнээс 3 төсөл арга хэмжээний тендер зарлаж, хэрэгжсэн байхад зураг төсвийн үнийг суутган тооцож аваагүй байна.   | 1           | 46,500.0 |               |     | 1               | 46,500.0 |         |     |                                      |                     |   |     |

|  |   |           |   |   |   |           |   |         |   |   |   |   |
|--|---|-----------|---|---|---|-----------|---|---------|---|---|---|---|
| Шинэжинст сумын ЗДТГ-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон 8 нэр бүхий газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайланд 636 м2, 1504 м2 талбай бүхий газрыг илүү бүртгэсэн байна. | 1 | -         |   |   | 1 | -         |   |         |   |   |   |   |
| Хог хаягдлын хураамжийн зардалд тухайн жилд 25,137,0 мянган төгрөг баталж, олгосон байхад хог хаягдлын хураамжийн орлогоор 3,500.0 мянган төгрөгийг оруулсан байна.                            | 1 | 9,300.0   |   |   |   |           | 1 | 9,300.0 |   |   |   |   |
| Тусгай зориулалтын материал, бусад материалын тайланг гаргаж ирүүлээгүй, нярвын бэлтгэсэн бараа материалын тайлангийн сарын орлого, зарлагын дүн ерөнхий дэвтэр дэх дүнгээс зөрүүтэй байна.    | 1 | -         |   |   | 1 | -         |   |         |   |   |   |   |
| Дүн  | 6 | 115,808.7 | 0 | - | 5 | 106,508.7 | 1 | 9,300.0 | 0 | 0 | 0 | 0 |

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 182/1/АУСБ0238/БНА  
2024/176/НА-СТА-ТМБ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын санхүүгийн тайланд 2019 онд бүртгэсэн 12,360,000 (Арван хоёр сая гурван зуун жаран мянган) төгрөгийн 206 тоо толгой ухна ишиг, 37,256,000 (Гучин долоон сая хоёр зуун тавин зургаан мянган) төгрөгийн 519 тоо толгой мал амьтан бүртгэлтэй байгаа нь малын А дансаар баталгаажуулж, завсрын аудитаар мал амьтан байхгүй гэсэн тайлбарыг албан бичгээр ирүүлсэн, 11 дүгээр сард мал амьтныг санхүүгийн тайлангаас хассан байсан байхад 12 дугаар сард хийсэн жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлээр байгаагаар тоолж, тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх "Тооллогын комисс дараахь үүрэгтэй: эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан

5040551

D/2024-ASH

шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1 дэх “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”, 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 49,616,000 (Дөчин есөн сая зургаан зуун арван зургаан мянган) төгрөгийн мал амьтдын асуудлыг тодруулж, арга хэмжээ авч ажиллан зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг, нягтлан бодогч Х.Доржсамбуу нарт даалгав<sup>2,3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 183/2/АО560238/БНА  
2024/176/АА - ОА - ТУЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн бусад нөөц дансанд 2018-2022 онуудад 5 төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийн 46,500,000 (Дөчин зургаан сая таван зуун мянган) төгрөгийг бүртгэж, үүнээс 3 төсөл арга хэмжээний тендер зарлаж, хэрэгжсэн байхад зураг төсвийн үнийг суутган тооцож аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.5 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

5040552

D/2024-ASH

1. Байгууллагын санхүүгийн тайланд нөөц дансанд бүртгэлтэй 46,500,000 (Дөчин зургаан сая таван зуун мянган) төгрөгийн зураг төсвийн үнийг холбогдох гүйцэтгэгч байгууллагуудаас суутган тооцож авлагыг барагдуулан зөрчлийг арилгаж, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг, нягтлан бодогч Х.Доржсамбуу нарт даалгав<sup>2,3</sup>.


**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>4</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 184/3/АОСБО233/БАА  
2024/176/НА - ОТА - ТМБ

Нөмрөн

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгааг тус байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан газартай тулган шалгахад Шинэжинст сумын ЗДТГ-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон 8 нэр бүхий газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайланд 636 м<sup>2</sup>, 1504 м<sup>2</sup> талбай бүхий газрыг илүү бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

5040556

D/2024-ASH

1. Байгууллагын санхүүгийн тайланд газрыг бүртгэн зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг, нягтлан бодогч Х.Доржсамбуу нарт даалгав<sup>2,3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 185/4/АУСБ0238/БНН  
2024/17С/НА - СТА - ТМБ

Нөмгөн

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй тусгай зориулалтын материал, бусад материалын тайланг нярав гаргаж ирүүлээгүй, нярвын бэлтгэсэн бараа материалын тайлангийн сарын орлого, зарлагын дүн ерөнхий дэвтэр дэх дүнгээс зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалт болон УСНББОУС-16, УСНББОУС-18 стандартыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

5040561

D/2024-ASH

1. Тусгай зориулалтын материал, бусад материалын тайланг тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв гаргаж, зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг, нягтлан бодогч Х.Доржсамбуу нарт даалгав<sup>2,3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно